



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг  
шинэчлэн тогтоож, балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Булган-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 60,918,837.00 (жаран сая есөн зуун арван найман мянга найман зуун гучин долоо) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 12,183,767.40 (арван хоёр сая нэг зуун наян гурван мянга долоон зуун жаран долоон төгрөг дөчин мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоож "Увс-А33А" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Булган-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Э.Пүрэвдэмбэрэл, "Увс-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Төмөрчөдөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132061349  
11-r\_huraldaan.docx

н бодлого, зохицуулалтын га  
04... дугаар сарын 18... өд  
1999... дугаар тогтоолын хавс  
Й, ҮЛДЭХӨРТӨГГҮЙ, АШИГ  
НИД БАЛАНСААС БАЛАНСА

'БУЛГАН-АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГҮЙ, АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ "УВС-АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

| д/д      | Хөрөнгийн нэр                    | Ашиглалтад<br>орсон он | Тоо<br>ширхэг | Нэг бүрийн үнэ<br>(төгрөг) | Нийт балансын үнэ,<br>хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)                    | Шинэчлэн тогтоох<br>нийт үнэ (төгрөг)                                                               | Цаашид<br>ашигдах<br>жил |
|----------|----------------------------------|------------------------|---------------|----------------------------|----------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|
| 1        | Зөөврийн асфальто<br>бетон завод | 2009.09.10             | 1             | 60,918,837.00              | 60,918,837.00                                                              | 12,183,767.40                                                                                       | 2                        |
| Нийт дүн |                                  |                        |               |                            | (жаран сая есөн зуун<br>арван найман мянга<br>найман зуун гучин<br>долоон) | (арван хоёр сая нэг<br>зуун наян гурван<br>мянга долоон зуун<br>жаран долоон мянга<br>дөчин төгрөг) |                          |